



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 08 өдөр

Дугаар 1144

Дадал сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тариалангийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, 24 дүгээр зүйлийн 24.1.1, 24.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд учруулсан хохирлыг тогтоох ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ахлагч:	Д.Гэрэлмаа	(Засаг даргын Тамгын газрын дарга)
Нарийн бичгийн		
Дарга:	Д.Сүнжидмаа	(Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)
Гишүүд:	Ч.Бат-Эрдэнэ	(Хөдөө аж ахуйн тасгийн дарга)
	Б.Урансайхан	(Газрын даамал)
	Г.Ган-Эрдэнэ	(Агац багийн Засаг дарга)
	О.Дугар	(Онон багийн Засаг дарга)
	Д.Батзориг	(Байгаль орчны хяналтын улсын байцаагч)
	С.Тэмүүлэн	(Татварын улсын байцаагч)
	Б.Ханхүү	(Хэсгийн цагдаа)

2.Сумын тариалангийн бүс нутагт нутаглаж буй айл өрхүүдэд тариалангийн тухай хууль тогтоомжийн сурталчилгааг тогтмол хийж, тариалангийн талбайд мал тэжээвэр амьтан оруулахгүй байлгах талаар малчид, мал бүхий иргэдтэй хамтарч ажиллахыг Онон багийн Засаг дарга О.Дугар, Агац багийн Засаг дарга Г.Ган-Эрдэнэ нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тариалангийн тухай хууль болон "Таримал ургамлыг мал, тэжээвэр амьтдаас хамгаалах журам"-д заасны дагуу тариалалт хийсэн нийт талбайнхаа 500 га тутамд манаа сахиул томилж, өөрийн эзэмшлийн нийт талбайг хашаажуулах, таримал ургамлаа мал, тэжээвэр амьтдаас хамгаалж ажиллахыг нийт газар тариалангийн үйл ажиллагаа эрхлэгч аж ахуй нэгжүүдэд даалгасугай.

010000170

4. Сумын Засаг даргын Тамгын газар, газар тариалангийн аж ахуй нэгжүүд, малчин иргэдтэй цаашид хамтран ажиллах гурвалсан байгуулж, жил бүр дүгнэж ажиллахыг Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн (Д.Сүнжидмаа)-д үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Хоридой)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.МӨНХХУЯГ